



ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАН СУМЫН
ЗАСАГ ДАРГА

Аргатай, 3 дугаар баг, Баянжаргалан сум,
Дундговь аймаг, 48020, Утас: (976) 7507 9911
Цахим шуудан: bayanjargalan@dundgovi.gov.mn,
Цахим хуудас: www.dundgovi.gov.mn

2024 - 05 - 01 № 1/143

танай _____-ны № _____-т

Албан шаардлагын хариу
хүргүүлэх тухай

Тус сумын Эм эргэлтийн сангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн "Зөрчил арилгах тухай" 198/A/1270318, 199/A/1270318, 200/A/1270318 тоот албан шаардлагыг хэрэгжүүлэхээр зохион байгуулсан ажлын мэдээллийг хүргүүлж байна.

1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах ажлын төлөвлөгөөг гарган, батлуулаад хэрэгжүүлэн ажиллаж байна.

2. Санхүүгийн албанаас холбогдох албан тушаалтан болон эмийн эргэлтийн сангийн зөвлөлд албан шаардлагыг танилцуулан, цаашид харилцагч байгууллагуудтай харилцан ойлголцож, мэдээллээр хангаж ажилладаг байх талаар танилцуулж мэдээлэл өгч ажиллав.

3. Албан шаардлагын хэрэгжилтийг ханган ажиллаж санхүүгийн үйл ажиллагааг хэвийн явуулахын тулд дараах ажлыг хийлээ. Үүнд:


а. Өндөр насжилттай авлага барагдуулах талаар – эм эргэлтийн сангийн зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 23-ний өдрийн хурлаас 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгасан өглөг авлагыг хоорондын тооцоогоор хааж, тооцоо дуусгахаар шийдвэрлэсэн тул 2024 оны 2-р улирлын санхүүгийн тайланд залруулга хийж тайлагнана.

б. Бараа материал, үндсэн хөрөнгийн тооллого зохион байгуулах талаар – сумын Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 15 өдрийн А/06 тоот захирамжаар тооллогын комисс томилон, 2024 оны 1-р улиралд багтаан тооллогын ажлыг зохион байгуулж, худалдан авалт, борлуулалтын тайлантай тулган баталгаажуулж тооцоог бодсон.

в. Нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг залруулж, цаашид зөрчлийг дахин гаргахгүй ажиллах талаар – татварын албанаас зөвлөгөө авах, 2023 оны

482403082

тайланд гарсан алдааг залруулж хамтран ажиллах талаар харилцагч байгууллагад албан бичиг хүргүүлэх, өмнөх оны тооцооллыг дахин гаргах, тулгах зэрэг ажлыг хийж гүйцэтгэлээ.Цаашид хуулиа хэрэгжүүлэн зөрчлийг дахин гаргахгүй ажиллах болно



О.УУГАНБААТАР